



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ БҮРЭН
ХАНГАГДААГҮЙГЭЭС ЗОНХИЛОН
ТОХИОЛДОХ ӨВЧЛӨЛ БУУРААГҮЙ, ЭМИЙН
ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ ТӨЛӨВШӨӨГҮЙ
БАЙНА**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ**

2021 оны 11 дүгээр сар



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1. Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрэн хангагдаагүй байна.	7
А.1. Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийг хууль, журмын дагуу бүртгэж байгаа ч эмийн хангалт, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого тодорхойгүй байна	7
А.2 Эмийн санхүүжилт жил бүр нэмэгдэж байгаа боловч зарцуулалтад хяналт тавих иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, мэдээлэл дутмаг, зарим тохиолдолд хяналт хэрэгжихгүй эрсдэл үүсэхээр байна.	8
А.3 Эмийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангах тогтолцоо бүрдээгүй, эм зүйн салбарын хүний нөөцийн бодлого тодорхойгүй байна.	13
БҮЛЭГ 2. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого бүрэн хэрэгжээгүйгээс хүн амын өвчлөл буураагүй, эмийн зохистой хэрэглээ төлөвшөөгүй байна.	16
Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын төлөвлөгөө боловсруулдаггүй, хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй бөгөөд эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын зорилтоор хэрэгжүүлсэн ч үр дүн тодорхойгүй байна.	16
Б.2 Эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааг төлөвлөлт, зохион байгуулалт сайтайгаар орон нутгийн түвшинд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сувгуудыг ашиглан тогтвортой урт хугацаанд, тогтмол, зохион байгуулж, үр дүнг үнэлж ажиллах шаардлагатай байна.	16
ДҮГНЭЛТ:	19
Холбогдох байгууллагын санал:	Error! Bookmark not defined.
Саналд өгсөн тайлбар: Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.	Error! Bookmark not defined.
ХАВСРАЛТУУД:	Error! Bookmark not defined.



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БИБ	Биологийн идэвхт бүтээгдэхүүн
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХШУДАХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЯТЭЭМТ	Яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлгийн тасаг



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орхон аймгийн эмнэлгийн нийт орны тоо	8
Хүснэгт 2	Орхон аймгийн эмнэлгүүд 2018-2020 онд улсын төсөв, ЭМДС-аас авсан санхүүжилт	8
Хүснэгт 3	Орхон аймгийн 2017-2020 оны зонхилон тохиолдох өвчний статистик үзүүлэлт	8
Хүснэгт 4	Орхон аймгийн эмнэлгүүд 2018-2021 онд ЭМДС-аас авсан санхүүжилт	9
Хүснэгт 5	ЭМДС-аас хөнгөлөлттэй эмийн жороор олгосон санхүүжилт	10
Хүснэгт 6	Халамжийн сангаас 2018-2021 онд протез, ортопедэд олгосон санхүүжилт	11
Хүснэгт 7	Хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд 2018-2021 онд олгосон эм, эмийн хэрэгслийн санхүүжилт	12

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Медипас эмнэлэгт 2019-2020 онд ЭМДС-аас өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо	11



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөө”-д аудит хийлээ.</p>
Аудитын зорилт	<p>Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Хүн амыг эмчилгээний өндөр идэвхитэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдсэн эсэх;• Төрөөс эмийн талаар баримтлах бодлого хэрэгжсэнээр хүн амын өвчлөл буурч, эмийн зохистой хэрэглээ төлөвшсөн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитад аймгийн ЗДТГ, аймгийн МХГ, ЭМГ, БОЭТ, ЭМДХ, эмийн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээд, иргэдийн аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.</p>
Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	<p>Аудитын хязгаарлалт үүсээгүй болно.</p> <p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000, тэдгээрт нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, Г.Оргилмөрөн, аудитор Б.Азжаргал, Т.Болормаа нар гүйцэтгэв.

Аудитыг 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, 2021 оны 11 дүгээр сарын 12-нд УАГ-т хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл

Короновируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, албад, албан тушаалтантай харилцахад цаг хугацааны хувьд хүндрэл үүссэн болно.

ЭМДХ-т 2021 оны 10 дугаар сарын 19-ны өдөр мэдээлэл ирүүлэх талаар албан бичгийг хүргүүлсэн боловч ирүүлсэн мэдээлэл хангалтгүй байлаа.

Мөн зарим байгууллагын холбогдох албан тушаалтнууд ковид-19 вирусийн халдвар авч, өвчтэй байсан зэрэг шалтгаанаар аудитад шаардлагатай баримт материалыг бүрэн хэмжээнд, шаардсан хугацаанд ирүүлэхгүй байсан нь аудит хугацаандаа хийгдэхгүй байх эрсдэлтэй байв.

Ерөнхий мэдээлэл

УИХ-ын 2014 оны 57 дугаар тогтоолоор “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар бодлогыг 2018-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө, 2020 оны А/103 дугаар тушаалаар 2020-2026 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг тус тус баталсан байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2017 оны 6/03 тогтоолоор “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийг баталсан байна.

Орхон аймагт 10 эм ханган нийлүүлэх байгууллага, 70 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна.

2018 онд 2, 2019 онд 6, 2020 онд 8, 2021 онд 4 тусгай зөвшөөрөл шинээр олгожээ.

ЭМДС-аас олгох хөнгөлөлттэй эмийг нийт 66 эмийн сантай гэрээ байгуулан олгож байна.



БҮЛЭГ 1. Хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрэн хангагдаагүй байна

А.1. Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийг хууль, журмын дагуу бүртгэж байгаа ч эмийн хангалт, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого тодорхойгүй байна

Монгол улсын дотооддоо үйлдвэрлэж байгаа болон импортолж буй эмийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу бүртгэх бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалаар баталсан “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам”-аар эм, эмийн түүхий эд, оношлуур, БИБ-ний бүртгэл, бүртгэлийн хугацаа сунгалт, өөрчлөлт, бүртгэлээс хасах шийдвэрийг Хүний эмийн зөвлөл гаргаж, Licemed бүртгэлийн системд эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч болон импортлогч ханган нийлүүлэгч байгууллагууд бүртгэдэг байна.

Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг баталсан Эрүүл мэндийн сайдын 2017, 2018 оны тушаалуудыг мөрдөж байсан ба 2020 оны А/625 дугаар тушаалаар Зайлшгүй шаардлагатай эмийн 9-р жагсаалт”-д 29 бүлгийн 571 нэрийн эм, “Хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн 2-р жагсаалт”-д 28 бүлгийн 251 нэрийн эмийг шинэчлэн баталжээ.

Орхон аймагт эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэргүй, харин эм ханган нийлүүлэх байгууллагын 10 салбар, 70 эмийн сан үйл ажиллагаа эрхэлж БОЭТ, ӨЭМТ-үүд, хувийн хэвшлийн эмнэлгүүдийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байна.

Монгол улсын Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартын 11.10-д “Нийтийн үйлчилгээтэй эмийн сан нь зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон, эмийн сангаар худалдахыг зөвшөөрсөн эмийн 90-ээс доошгүй хувийн хангах нөөцтэй байна” гэж заасан бөгөөд аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудын нөөц хэвийн байдаг байна.

Орхон аймаг нь хүн ам төвлөрсөн, зам харилцаа, дэд бүтэц сайн хөгжсөн тул эмнэлэг, эмийн сан, эм хангамжийн байгууллагууд улсын хэмжээнд тасарснаас бусад эм, эмнэлгийн хэрэгслийг тасралтгүй хангаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Аймгийн БОЭТ нь 2018 онд 1,929.8 сая төгрөг, 2019 онд 2,037.8 сая төгрөг, 2020 онд 2,254.8 сая төгрөгийн эмийн төсвийг зарцуулсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10¹¹-д “Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг оролцуулахыг хориглоно” гэсэн заалтаар үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжин дотоодын үйлдвэрийн эм, хэрэгслийг тусад нь багц болгож тендер зохион байгуулан үйл ажиллагаа явуулдаг байна.

Орхон аймгийн хэмжээнд импортын, үнэтэй эмийг сонгон хэрэглэдэг нь үндэсний үйлдвэрийн эмийн агууламж, үйлчлэлийн талаар иргэд мэдлэг мэдээлэл дутмаг байдаг байна.

Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээний сан бүрдүүлэх, түүгээр хэрэглэгчдийг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд аюулгүй, чанартай эм хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цахимд суурилсан Licemed программыг хөгжүүлэн ашиглаж байна.

Олон нийтэд нээлттэй хэсгээр дамжуулан (www.druginfo.mohs.mn) эм, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүн, түүхий эд, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг иргэд, байгууллага, эмч, эмнэлгийн ажилчид, эм зүйч, эм найруулагчид



авах боломжтой байна. Хэдийгээр нээлттэй систем боловч олон нийтэд таниулж, ашиглах мэдээллээр хангаагүй байна.

Иймд системд сайжруулалт хийн, мэдээллийн иж бүрэн байдлыг хангаж, хэрэглэгч талуудын мэдлэг, хэрэглээг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

А.2 Эмийн санхүүжилт жил бүр нэмэгдэж байгаа боловч зарцуулалтад хяналт тавих иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, мэдээлэл дутмаг, зарим тохиолдолд хяналт хэрэгжихгүй эрсдэл үүсэхээр байна

Орхон аймагт 2020 оны байдлаар Жаргалант сумын эрүүл мэндийн төв, БОЭТ, ортой хувийн эмнэлэг 13, сувилал 1, үүдэн хувийн эмнэлэг 56, өрхийн эрүүл мэндийн төв 8, нийт 80 эмнэлэг, сувилал үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр эмнэлгүүдийн орны тоог ЭМГ-ын даргын тушаалаар жил бүр баталжээ. Эмнэлгүүдийн орны нийт тоо 2018 оноос 135-аар өссөн нь хувийн хэвшлийн барилга байгууламжийн хүчин чадлаас шалтгаалжээ.

Хүснэгт 1. Орхон аймгийн эмнэлгийн нийт орны тоо

д/д	Эмнэлэг	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	БОЭТ	465	465	464	464
2	Жаргалант сумын ЭМТ	12	12	21	21
3	Хувийн эмнэлэг /ортой/	419	432	494	546
	Нийт	896	916	979	1031

БЭОТ, Жаргалант сумын ЭМТ болон ӨЭМТ-үүд нь 2018-2020 онд улсын төсвөөс санхүүжиж байсан бол 2021 оноос ЭМД-ын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлээр, ЭМДС-аас 100% санхүүждэг болсон. Санхүүжилтийг эх үүсвэрээр харуулбал:

Хүснэгт 2. Орхон аймгийн эмнэлгүүд 2018-2020 онд улсын төсөв, ЭМДС-аас авсан санхүүжилт /сая төгрөг/

д/д	Он	Санхүүжилтийн эх үүсвэр	БОЭТ	Жаргалант сумын ЭМТ	ӨЭМТ-үүд	Хувийн эмнэлэг
1	2018	Улсын төсөв	9,453.7	316.4	1,417.4	
		ЭМДСан	4,354.3	11.3	167.3	1,318.1
2	2019	Улсын төсөв	11,051.4	343.8	1,634.9	
		ЭМДСан	4,795.3	29.9	354.1	1,528.0
3	2020	Улсын төсөв	12,991.5	362.4	2,652.4	
		ЭМДСан	5,063.4	30.1	361.2	3,422.7
		Нийт дүн	47,709.6	1,093.9	6,587.3	6,268.8

Аймгийн Эрүүл мэндийн газрын ашигладаг health.info системд нэгтгэсэн зонхилон тохиолдох өвчин эмгэгийн статистик үзүүлэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Орхон аймгийн 2017-2020 оны зонхилон тохиолдох өвчний статистик үзүүлэлт /10,000 хүн тутамд/

д/д	Өвчний нэр	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Амьсгалын тогтолцооны өвчин	1,822	1,444	1,680	1,315
2	Хоол шингээх эрхтний өвчин	638	509	1,273	1,443
3	Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин	543	461	888	882
4	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	593	580	1,256	1,127
5	Бэртэл хордлого ба бусад гаднын шалтгааны дагавар	214	210	209	82
6	Халдварт бус өвчлөл	37,028	25,802	55,754	59,399
	Нийт дүн	40,838	29,006	61,060	64,248



Дээрх статистик үзүүлэлтээс дүгнэвэл зонхилон тохиолдох өвчлөл 2017 оноос 57.3 хувиар өссөн ба хоол шингээх эрхтний, цусны эргэлтийн тогтолцооны болон халдварт бус өвчний өвчлөл эрс нэмэгджээ.

ЭМДС-аас тогтмол санхүүжилт авсан эмнэлгүүдийн мэдээллийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Орхон аймгийн эмнэлгүүд 2018-2021 онд ЭМДС-аас авсан санхүүжилт /сая төгрөг/

д/д	Эмнэлэг	2018 он		2019 он		2020 он		2021 оны эхний 8 сарын байдлаар	
		Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн	Хүний тоо	Дүн
1	БОЭТ	162,110	4,354.3	169,841	4,795.3	187,151	5,063.4	119,734	7,431.6
2	Жаргалант сумын ЭМТ	525	11.3	1,247	29.9	873	30.1	1,019	36.9
3	ӨЭМТ /8/	7,268	167.3	19,619	354.1	17,523	361.2	6,756	229.0
4	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын эмнэлэг, сувилал	1,617	177.8	1,130	124.3	352	59.1		
5	Хувийн эмнэлэг /11/	7,240	1,140.2	10,713	1,403.8	19,314	3,363.6	15,032	3,789.1
6	Шүдний эмнэлэг /5/			2,944	176.6	2,845	170.7		
7	Лаборатори /Онош/					60	3.6	5,456	59.8
Нийт дүн		178,760	5,850.9	202,550	6,884.0	228,118	9,051.7	147,997	11,636.4

2020 оны байдлаар ЭМДС-ийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 27.6%-аар, санхүүжилтийн дүн 54.7%-аар тус тус өссөн байна. 2021 оны эхний 8 сарын байдлаар 11,636.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 2018 оны үзүүлэлттэй харьцуулахад 5,763.1 сая төгрөгөөр буюу 98.9%-аар өсжээ.

ЭМДЕГ-ын health.go.mn нэгдсэн системээр мэдээллийг хянаж, санхүүжилт олгодог бол эмнэлгүүд e-health цахим системээр өвчтөний мэдээллийг бүртгэдэг ба нэгдсэн цахим системийг 2017 оноос ашиглаж эхэлсэн байна.



Хяналтын эмч эрүүл мэндийн байгууллагын бүртгэсэн мэдээлэлд 100% хяналт хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд нэгдсэн системээс 10%-д нь шууд хяналт хэрэгжүүлэхээр тохируулсан байна.

Энэ нь эрүүл мэндийн байгууллагуудад хяналт хэрэгжүүлэхгүйгээр санхүүжилт олгох, нэг бүрчлэн хяналт хэрэгжүүлснээр цаг хугацаа их зарцуулж, санхүүжилт олгохгүй байх зэрэг эрсдэл үүсгэхээр байна. Тухайлбал 2020 онд БОЭТ нийт 188,928 үйлчлүүлэгчийн 5,156.8 сая

төгрөг нэхэмжилж, ЭМДХ 1,777 үйлчлүүлэгчийн 93.4 сая төгрөгийг хасаж, 187,151 үйлчлүүлэгчийн 5,063.4 сая төгрөгийг олгожээ.

Үйлчлүүлэгч ЭМДС-аас авсан үйлчилгээний талаарх e-daatgal цахим систем ашиглаж эхэлсэн боловч Орхон аймгийн хэмжээнд 2020 онд 500, 2021 оны 08 дугаар сарын байдлаар 1,076 хүн ашиглаж байна. Энэ нь 2020 онд нийт эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 0.2%, 2021 онд үйлчлүүлсэн иргэдийн 0.7%-ийг эзэлж байгаа бөгөөд иргэдэд сурталчлан таниулах үйл ажиллагаа хангалтгүйг илтгэж байна.



Иймд ЭМДС-ийн үйлчилгээнд хамрагдсан иргэн бүр өөрийн авсан үйлчилгээг хянах edaatgal цахим системийг сурталчлан таниулах, гар утас ашигладаггүй иргэдэд мэдээллийг хэрхэн хүргэх боломжийг тооцон судалж, иргэдийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ЭМДС-аас хөнгөлөлттэй эмийн жороор 2018-2020 онд 150,470 иргэнд 2,241.7 сая төгрөгийн хөнгөлөлт олгосон байна. Үүнийг оноор харуулбал:

Хүснэгт 5. ЭМДС-аас хөнгөлөлттэй эмийн жороор олгосон санхүүжилт /сая төгрөг/

д/д	Он	Хөнгөлөлттэй эм олгосон эмийн сангийн тоо	Хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлсэн иргэний тоо	Хөнгөлөлттэй олгосон дүн
1	2018	20	47,094	907.2
2	2019	31	51,084	1,061.0
3	2020	57	52,292	1,228.4
4	2021 оны эхний 8 сар	66	55,373	1,829.1
	Нийт дүн		205,843	5,025.7

2018 оноос хойш хөнгөлөлттэй эмээр үйлчлэх эмийн сан, үйлчлүүлэх иргэн, хөнгөлөлт үзүүлсэн санхүүжилтийн дүн жил бүр өссөн байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/101 тушаалаар баталсан “ЭМДС-аас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад эмийн ерөнхий нэршлийг нэмэгдүүлэхгүйгээр худалдааны 33 нэршлийн эмийг нэмж, ЭМДС-аас 141 ерөнхий нэршлийн 541 худалдааны нэршлийн эмийг 30-70% хүртэл хөнгөлөлт үзүүлдэг болсон байна.

ЭМДС-ийн health.go.mn нэгдсэн системд Орхон аймагт 2020 оны 11 сараас 2021 оны 9 хүртэлх хугацаанд хөнгөлөлттэй олгосон эмийн жагсаалтад хамгийн их хөнгөлөлттэй олгосон эм нь даралт зүрх судасны /амло-денк, вальсакор, лориста, предизин/ 37.4 сая төгрөг, ходоод гэдэс, элэг цэсний /нольпаза, урсомон, урсофальк/ 27.8 сая төгрөг, цус шингэлэх, өөх хайлуулах /аторис, клопи-денк/ 17.2 сая төгрөг, тархины брайнакт эм 18.7 сая төгрөг байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эмийн сангууд эм ханган нийлүүлэх төвөөс бөөний үнээр худалдан авч, дунджаар 15-30% нэмж борлуулдаг байна. Зарим эм ханган нийлүүлэх төвийн салбарууд Улаанбаатар хотын эм хангах нийлүүлэх байгууллагаас ч өндөр үнээр нийлүүлдэг тул Улаанбаатар хотоос хямд үнэтэйг сонгож, тээвэрлэн борлуулдаг байна.

ЭМДС-аас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтад бөөний үнээс хямд өртөгтэй эм байдаг бөгөөд тэдгээрийг иргэдэд олгох боломжгүй, жор бичсэн ч борлуулдаггүй байна. Тухайлбал “урсофальк эмийн бөөний үнэ ширхэг нь 1,540 төгрөг байхад ЭМДС-аас хөнгөлөлт үзүүлэх нь 1,190 төгрөг, брайнакт эмийн бөөний үнэ ширхэг нь 1,090 төгрөг байхад даатгалын сангаас 980 төгрөг олгодог байна.

2020 он хүртэл хөнгөлөлттэй эмийн баталсан төсвийг гэрээтэй эмийн сангуудад хуваарилж олгодог байсан бөгөөд ЭМД-ын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор бүх эмийн сангуудтай гэрээ хийж, гүйцэтгэлээр санхүүждэг болсон байна.

Мөн сарын эхэнд эмчээр жороо бичүүлж, сарын эхний 10 хоногт эмийн сангуудад санхүүжилт хүрэхгүй дуусдаг байсан бол өнөөгийн байдлаар тухайн сардаа жороо бичүүлж, өөрт ойрхон аль ч эмийн сангаас авах боломжтой болсон байна.

Ингэснээр иргэд жор бичүүлэх болон эмийн сангийн санхүүжилт дуусахаас өмнө оочирлох шаардлагагүй болсон давуу талтай үүссэн боловч эмийн хэт их хэрэглээ нэмэгдэж, эмийн зүй зохистой хэрэглээг хянах боломжгүй болох эрсдэл үүсгэхээр байна.



Аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс болон ЭМГ-т хөнгөлөлттэй олгох эмийн санхүүжилтийг ЭМДС-аас жил бүр санхүүжүүлж байгаа ч өвчин эмгэг хэрхэн буурсан талаар тодорхой судалгаа хийдэггүй байна.

Засгийн газрын 2012 оны 153-р тогтоолын дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зайлшгүй хиймэл түнхний үе солих бол 6.0 сая төгрөг, хиймэл өвдөгний үе солих бол 5.0 сая төгрөгийг аймгийн халамжийн сангаас санхүүжүүлж ирсэн байна. Халамжийн сангаас 2018-2021 онд протез, ортопедийг санхүүжүүлсэн байдлыг харуулбал:

Хүснэгт 6. Халамжийн сангаас 2018-2021 онд протез, ортопедэд олгосон санхүүжилт /сая төгрөг/

№	Олгосон байдал	2018 он		2019 он		2020 он		2021 он	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	ААН-ээр дамжин	20	116.0	20	118.0	14	81.0	1	6.0
2	Иргэнд	15	75.8	11	61.0	17	92.0	1	5.0
	Нийт дүн	35	191.8	31	179.0	31	173.0	2	11.0

Мөн ЭМД-ын үндэсний зөвлөлийн 2020 оны 5 дугаар тогтоолоор “Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээ, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсны дагуу аймгийн БОЭТ болон ЭМДХ-тай 2021 оны 03 сараас гэрээ байгуулан, өртөг өндөр мэс ажилбарыг 792 хүнд хийж, 702.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Мөн ЭМДГ 2019 оноос хойш Медипас эмнэлэгтэй гэрээ байгуулж, 2019-2020 онд 82 иргэний 34.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Медипас ХХК-д 2019-2020 онд ЭМДС-аас өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээнд нийт 82 иргэн хамрагдсанаас болрыг буталж соруулж уутнаас нь авч хиймэл болор суулгах мэс засал 21.7%, хоол боловсруулах замын нарийн хөлтэй, өргөн суурьтай ур дурангаар авах мэс засал 19.3%, цөсний хүүдий авах /дурангаар эсвэл нээлттэй/, элэг нойр булчирхай тайрах, хөнгөвчлөх мэс засал 12%, оёх багажаар шамбармыг тайрч сойх мэс засал 11% -ийг тус тус эзэлж байна. Мэс заслын төрлөөр ангилан, хүний тоогоор харуулбал дараах байдалтай байна.

Дүрслэл 1. Медипас эмнэлэгт 2019-2020 онд ЭМДС-аас өндөр өртөгтэй мэс заслын тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо /мэс заслын төрлөөр/



Харин 2021 оны 3 дугаар сараас БОЭТ, ЭМДХ-тай гэрээ байгуулж өндөр өртөг бүхий эмчилгээ оношилгооны тусламж үйлчилгээ үзүүлдэг болсон байна. Оны



эхний 8 сарын байдлаар өндөр өртөг бүхий эмчилгээ оношилгоо буюу зүрхний эхо, ходоодны дуран, компьютер томографд нийт 767 иргэн хамрагдсан байна.

ЭМДХ-т health.go.mn программаас өмнөх оны мэдээллүүдийг дэлгэрэнгүй авах боломжгүй, ЭМДЕГ-аас дамжин гарах боломжтой гэх боловч хугацаа их шаардаж, ирүүлсэн мэдээлэл нь ашиглалтын шаардлага хангахгүй, он оноор ирүүлэх мэдээллийг зөвхөн нэг оныг гаргаж бусад оныг гаргаагүй байх зэрэг хүндрэл тулгарсан.

Ядуу эмзэг бүлгийн хүн амыг ЭМДС-аас хариуцаж үйлчилгээ үзүүлж байгаа ч шаардлагатай мэдээлэл хангалтгүй байна.

Орхон аймагт амьжиргааны түвшин доогуур ядуу эмзэг бүлгийн иргэд 2018 онд 11,841, 2019 онд 11,514, 2020 онд 11,431, 2021 онд 11,324 бүртгэлтэй байна.

Эдгээр ядуу эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээний зардлыг ЭМДС-аас санхүүжүүлэх ёстой бөгөөд 2021 оны 9 сарын байдлаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан 12,719 иргэнд 3,220.2 сая төгрөг зарцуулсан байна.

Өмнөх онуудад ядуу эмзэг бүлгийн иргэдэд зарцуулсан төсөв, ямар өвчин зонхилон тохиолдож байгаа талаарх мэдээллийг авахаар ЭМДХ-т хандсан ч мэдээллийг ирүүлээгүй байна.

Харин аймгийн Засаг даргын захирамжаар 2018 онд 6.5 сая төгрөг, 2019 онд 1.5 сая төгрөг, 2020 онд 7.5 сая төгрөг, 2021 онд 5.0 сая төгрөг, нийт 20.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг нэмэлт амин дэмээр хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг ЭМГ зохион байгуулсан байна.

ЭМГ 2018 онд Монфа трейд ХХК, 2019-2020 онд Монос фарм ХХК, 2021 онд Монос Орхон Фарм ХХК-тай амин дэм худалдах, худалдан авах гэрээ байгуулж ажиллажээ. Гэрээгээр нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг иж бүрэн байдал, чанарын шаардлага хангасан эсэх, хүлээн авсан анхан шатны нотлох баримт хангалтгүй, амин дэмийг ӨЭМТ-дэд олгосон эсэх нь тодорхойгүй, амин дэм олгосноор жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн биед үр нөлөө үзүүлсэн талаар судлаагүй, орон нутгаас жил бүр олгож буй санхүүжилт үр дүнтэй эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 129/100 тушаалаар батлагдсан “Төлбөрийг нь төр хариуцах журам”-ын дагуу БОЭТ-ийн хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар орж, хяналтад байдаг хөдөлмөрийн чадвар алдсан хүмүүст дараах 6 төрлийн эм, тариаг сар бүр үнэ төлбөргүй олгодог байна.

Хүснэгт 7. Хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдэд 2018-2021 онд олгосон эм, эмийн хэрэгслийн санхүүжилт /сая төгрөг/

№	Эмийн төрөл	2018 он		2019 он		2020 он		2021 оны 9 сар	
		хүний тоо	дүн	хүний тоо	дүн	хүний тоо	дүн	хүний тоо	дүн
1	Сахарын эм	2,451	15.4	2,003	17.9	1,953	16.6	1,879	10.0
2	Сахарын тариа	1,678	54.2	2,276	62.1	2,469	66.3	2,062	42.5
3	Сахарын бус тариа	20	0.5	18	0.9	20	0.9	350	1.1
4	Бамбай булчирхай эм	246	0.6	277	0.7	371	1.7	17	1.0
5	Сэтгэц нөлөөт эм	761	3.7	720	5.1	871	5.5	619	0.5
6	Хавдрын эм	-	-	-	5.7	339	6.9	27	4.9
	Нийт дүн	5,156	74.4	5,294	92.4	6,023	97.9	4,954	60.0



А.3 Эмийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангах тогтолцоо бүрдээгүй, эм зүйн салбарын хүний нөөцийн бодлого тодорхойгүй байна

Эмийн үндэсний бодлого нь Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын бодлогод тусаж, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаагаар дамжин хэрэгжихээр хуульчилсан байна.

Аймгийн ЗДТГ, МХГ, ЭМГ, ЭМДХ зэрэг байгууллагууд нь хууль, эрх зүйд тусгасан чиг үүргийн хүрээнд ажилладаг ба нэгдсэн зохицуулалт байхгүй байна. Дээрх байгууллагуудын мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтоор дараах чиг үүрэгтэй байна.

- ЗДТГ-ын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн нь эрүүл мэндийн салбарын асуудалд бодлого арга зүйгээр хангах, хянах.

- МХГ-ын эм био бэлдмэлийн улсын байцаагч нь зах зээлд бүртгэлгүй эм худалдаалах, мансууруулах сэтгэцэд нөлөөт эм, эмийн сан стандарт шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавих хяналт шалгалт хийх, акт тавих.

- ЭМГ-ын эмийн мэргэжилтэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмийн хэрэглээ, амин чухал эмийн нөөц, хадгалалтад хяналт тавих, нийтийн үйлчилгээтэй эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагуудад стандартын хяналт тавих, зөвлөн туслах, иргэдийг зохистой хэрэглээний сургалт мэдээллээр хангах.

- ЭМДХ-ийн байцаагч нутаг дэвсгэрийн хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, эрүүл мэндийн даатгалын гэрээний хэрэгжилтийг үнэлэх, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах.

Тусгай зөвшөөрөл олгох аймгийн комиссын ажлын алба буюу аймгийн Эрүүл мэндийн газраас аудитын хамрах хүрээн дэх хугацааны тусгай зөвшөөрөл хүсэгчийн холбогдох бүх баримт материал, тусгай зөвшөөрлийн комиссын хурлын 2019, 2020 оны материалыг ирүүлээгүй болно.

Орхон аймгийн ЭМГ-ын дэргэдэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2018 оны 01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэж 2018 онд “Орхон” эм ханган нийлүүлэх байгууллагад, 2021 онд Ази фарм ХХК-ийн “Орхон Ази фарм” эм ханган нийлүүлэх байгууллагад аймгийн Засаг даргын захирамжаар тус тус мансууруулах сэтгэц нөлөөт эм худалдан борлуулах эрх олгохоор шийдвэрлэсэн нь Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 24.1, 24.2 дахь заалт, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8.2 дахь заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам”-ын 1.2 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Мөн эмийн сангуудад мансууруулах сэтгэц нөлөөт эм, сэтгэц нөлөөт эмийг тус тус худалдан борлуулах эрх, тусгай зөвшөөрөл олгох аймгийн комиссын хурлын шийдвэрийг үндэслэж, аймгийн Засаг даргын захирамжаар олгож буй нь ЭМС-ын 2015 оны 68 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан журмын 1.3 дахь заалттай нийцэхгүй.

Эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл шинээр олгох асуудлыг 2 үе шаттай зохион байгуулаагүй, Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулсан хэрэгцээний тодорхойлолт олгох, хэрэгцээний үнэлгээг мэргэжлийн нийгэмлэг, холбоогоор гүйцэтгүүлэх ажлыг огт хэрэгжүүлээгүй байна.



Мөн шинжээчийг хэрхэн сонгон шалгаруулсан талаарх баримт материалыг ирүүлээгүй бөгөөд ЭМГ-ын 2018 оны А/24 дугаар тушаалаар 3, 2019 оны А/14 дүгээр тушаалаар 4 орон тооны бус шинжээчийн багийг томилсон байна.

Аймагт эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох асуудалд ЭМС-ын 2013 оны 145 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага”, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 298 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-ыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон, сэргээсэн, гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулсан эм хангамжийн байгууллагын талаарх мэдээллийг аймгийн Эрүүл мэндийн газар тусгай зөвшөөрлийн бүртгэлийн программд байршуулаагүй, тусгай зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор бүтэц, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийх ажлыг зохион байгуулаагүй байна.

Дэлгэрэх цоморлог эмийн сан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээндээ тусгай зөвшөөрлийн талаараа тусгаагүй, Цагаан цээнэ, Орхон-1 эмийн сангуудад хувийн эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа буюу “ЭХ” кодоор, Дэлгэрэх цоморлог эм ханган нийлүүлэх байгууллагуудад эмийн сангийн “ЭСХ” кодоор тус тус тусгай зөвшөөрөл олгосон байна.

Мөн 2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 70 эмийн сангийн 25-д эм ханган нийлүүлэх байгууллагын буюу “ХХ” кодоор тусгай зөвшөөрөл олгосон байна.

ЭМС-ын 2021 оны 06-р сарын 23-ны өдрийн А/400 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам”-аар аймаг, нийслэлд ажиллах тусгай зөвшөөрлийн комиссын даргаар аймаг, нийслэлийн Засаг дарга ажиллахаар зохицуулагдсан байтал Орхон аймгийн энэхүү комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулаагүй, тус комисс 2021 оны 08 дугаар сард хуралдаж /04 дүгээр хурал/ Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, шинээр эрүүл мэндийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хойшлуулах, тусгай зөвшөөрлийг цуцлах, хаяг шилжүүлэх шийдвэрүүдийг тус тус гаргасан байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт ажиллагсдын 10.1%-ийг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд ажиллагсад, 30%-ийг БОЭТ-ийн, 9%-ийг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын, 9%-ийг Эрдэнэт сувиллын цогцолборын, 17%-ийг эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн санд ажиллагсад, 1.2%-ийг бусад байгууллага эзэлж байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 6/04 тогтоолоор "Эмч" дэд хөтөлбөр баталсан бөгөөд аймгийн эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилтны мэдлэг чадвар, ёс зүйн төлөвшлийг сайжруулах, техник тоног төхөөрөмжийг ашиглан хэрэглэх аргад цаг алдалгүй суралцах нөхцөл боломжоор хангах, шинэ технологи арга барилыг орон нутагт нутагшуулах, орчин үеийн эмчилгээ, оношилгооны аргыг эх орондоо нэвтрүүлэх, хүний нөөцийг цогцоор нь бэлтгэх арга хэмжээг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэх, эрүүл мэнд нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна.

"Эмч" дэд хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хувийн хэвшлийн эмийн сангийн 10 эм зүйчид 5.0 сая төгрөгийн тусламж үзүүлж, БНСУ-д зохион байгуулагдсан “олон улсын форум экспо”-д оролцуулжээ.

Орон нутагт хувийн хэвшлүүдийн нэгдсэн эмнэлгийн 10 байгууллагыг нэгтгэсэн "Чандмань-Эрдэнэ" холбоо, эмийн сангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 70 байгууллагыг нэгтгэсэн "Эм" холбоо зэрэг төрийн бус байгууллагууд



үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр төрийн бус байгууллагууд нь МХГ, ЭМГ, БОЭТ-тэй хамтран хувийн хэвшлийн эмнэлэг болон эмийн сангийн ажилчдын дунд сургалт семинар шагнал урамшуулал, тэмцээн уралдаан, зохион байгуулан хамтран ажилладаг байна.

Эмийн зохицуулалтын чиглэлээр төр захиргааны байгууллага, хувийн хэвшилтэй хамтран “Антибиотикийг жороор олгож хэвшицгээе”, “Жор бичилтийн аян”, “Антибиотикийн зохистой хэрэглээ” зэрэг аяныг зохион байгуулсан байна.

Эмийн сангуудын дунд “Нянгийн тэсвэржилтээс сэргийлье”, эм ханган нийлүүлэх байгууллагад Эмийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага MNS 5530:2014 Эмийн санд тавих ерөнхий шаардлага MNS 5260:2015, Эмийн жор бичилт, жорын маягтад тавих ерөнхий шаардлага MNS 5376:2016” зэрэг стандартын дагуу жилийн турш хувийн хэвшлийн байгууллагад хяналт тогтмол хийж ирсэн байна.

Төрийн болон төрийн бус байгууллага иргэд эм эмнэлгийн хэрэгслийн талаар www.druginfo.mohs.mn сайтаар дамжуулж эмийн худалдааны болон олон улсын нэр, тун, хэлбэр хэмжээ, хэрэглэх заавар, бүртгэлийн хугацаа, ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгчийн нэр, үйлдвэрлэгч улс зэрэг мэдээллийг авч, ашиглаж байна.


ЭМХТ-өөс эм зүйч, эм найруулагч нарт "эм барих" лицензийг 3-5 жилийн хугацаатай олгодог ба жил тутам 6 кредитийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагддаг байна. Мэргэжил дээшлүүлэх болон бусад сургалтуудаас үр дүн гарсан эсэх, хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн талаар аймгийн хэмжээнд нэгдсэн судалгаа, тайлан байдаггүй байна.

Жил бүр зохион байгуулагддаг эмнэл зүйн эм зүйчдийн эрдэм шинжилгээний хурал, сургалт, ЭМХТ-өөс зохион байгуулсан мэргэшлийн зэргийн шалгалтад 3 эм зүйч 95%-аас дээш дүн авч амжилттай оролцож “ахлах зэрэг”, Улсын 1-р төв эмнэлгийн ehealth программтай танилцах сургалт, онлайн сургалтаар IVCO компаниас зохион байгуулсан “Ангиотензин хувиргагч ферментэд нөлөөлдөг болон Кальцийн сувагт хориг үүсгэгч даралтын эмүүдийн онцлог”, “Ажлын байран дахь стресс буюу, ажлаас халшрах хам шинж”, UKI Corporate Citizenship Accenture-аас зохион байгуулсан “Дижитал ур чадвар” зэрэг сургалтуудад эм зүйчид хамрагдсан байна.



БҮЛЭГ 2. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого бүрэн хэрэгжээгүйгээс хүн амын өвчлөл буураагүй, эмийн зохистой хэрэглээ төлөвшөөгүй байна

Б.1 Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын төлөвлөгөө боловсруулдаггүй, хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй бөгөөд эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын зорилтоор хэрэгжүүлсэн ч үр дүн тодорхойгүй байна



Аймгийн ИТХ-ын 2017 оны 6/03 тогтоолоор "Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого"-ын баримт бичгийг баталсан байна. ЭМГ нь тус бодлогын хэрэгжилтийн тайланг 9 бүлэг асуудлаар жил бүр нэгтгэн ЗДТГ-т хүргүүлж, ЗДТГ-аас хянаж ЭМЯ-д хүргэгддэг байна.

Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн жил бүрийн эцэст эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн тайлангийн биелэлтэд хяналт хэрэгжүүлж байгууллагын удирдлагын зөвлөлд танилцуулдаг байна.

Эм зүйн тусламж үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан 7 дэд зорилтын 12 зүйл заалтын биелэлтийг 2018 онд 82.8%, 2019 онд 85%, 2020 онд 90.35%-

аар тус тус үнэлсэн байна.

Орхон аймагт эрүүл мэндийн хөтөлбөрт тусгасан эмийн талаарх зүйл заалтын хэрэгжилтийг жил бүр ЭМЯ-нд хүргүүлдэг бөгөөд дараа оны эхэнд Засаг даргын зөвлөлийн хурал болон аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, дараа оны хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулдаг байна.

Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн жил бүрийн Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлж удирдлагын зөвлөлд дараа онд анхаарах асуудлаар зөвлөгөө санал өгдөг байна. Гэвч удирдлагын зөвлөлд хүргүүлсэн зөвлөгөө, саналыг дараа онд хэрхэн хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэхээр ямар арга хэмжээ авч биелэлтийг хэрхэн тооцсон талаар тодорхой тусгаагүй нь тус хяналт, шинжилгээ үр дүнгүй байна.

Эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ЭМЯ болон аймгийн ХШҮДАХ-ээс хяналт хэрэгжүүлээгүй, харин үндэсний томоохон зорилт хөтөлбөрүүдэд хяналт хэрэгжүүлдэг байна.

Б.2 Эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааг төлөвлөлт, зохион байгуулалт сайтайгаар орон нутгийн түвшинд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сувгуудыг ашиглан тогтвортой урт хугацаанд, тогтмол, зохион байгуулж, үр дүнг үнэлж ажиллах шаардлагатай байна



“Эмнэл зүйн удирдамж, хөтөч боловсруулах журам”-ыг ЭМС-ын 2013 оны 174 дүгээр тушаалаар баталсан бөгөөд ЭМЯ-ны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоод болон томилогдсон ажлын хэсгүүд болон төв эмнэлгүүд боловсруулахаар журамласан байна. Орон нутгийн хэмжээнд стандарт батлагдаагүй болон ЭМС-ын тушаалаар батлаагүй зарим эмнэлгийн тусламжийн эмнэл зүйн удирдамжийг боловсруулж, тухай бүр шинэчлэн мөрддөг байна.

ЭМС-ын 2019 оны А/414 дугаар тушаалаар баталсан “Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам”-ыг аймгийн БОЭТ мөрдөж байна. Тус хороо нь 2018-2020 онуудад дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж тасгуудын жор бичилтэд хяналт хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЭМГ-аас жор, эмийн санхүүжилт, зонхилон тохиолдох өвчний гэх зэрэг нэгтгэсэн тоон мэдээ, статистик дүн гардаг боловч түүнд дүн шинжилгээ хийдэггүй, хүн амын өвчлөл буураагүй, эмийн зохистой хэрэглээ төлөвшөөгүй байна.

Эм олгох үйл ажиллагаанд тавих хяналт MNS 5260-2015:Эмийн санд тавих нийтлэг шаардлагын 6.1-д “Эмийн сангийн ...дотоод хяналтын үйл ажиллагааг зөвхөн эм зүйч гүйцэтгэнэ” гэж заасан. Аймгийн БОЭТ-д эмчлүүлэгчийн эмийн захиалгыг тасгийн эрхлэгч дарга хянаж, эм зүйн албанд өгч, тасгийн эм зүйч эмийн олголтод өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлдэг байна.

Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн эм олголтод тавих дотоод хяналтыг эмийн сангийн эрхлэгч-эм зүйч хэрэгжүүлэх чиг үүрэгтэй боловч ихэнх эмийн сан 1-2 эмийн санч, эм зүйч ажиллаж байгаа нь тус чиг үүргийг хэрэгжүүлсэн эсэхийг тодорхойлж, нотлох боломжгүй байлаа.

Аймгийн МХГ-аас 2018 онд 49, 2019 онд 62, 2020 онд 54 эмийн санд хяналт шалгалт хийсэн ба шалгалтаар жортой олгох эмийг жоргүй олгодог, эмийн жор бичилтэд үнэлгээ хийдэггүй эмийн гаж нөлөө илрэх үед зохих арга хэмжээг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны удирдамжгүй, эмийн жор бичилт, жорын маягтад тавих ерөнхий шаардлага MNS5376:2016 зэрэг стандартын дагуу бичээгүй, бичилт хийж буй өрхийн эрүүл мэндийн төвийн тамга тэмдэг, гарын үсэггүй, жор болон эмчилгээний 1-р маягтын хуудсанд бичихдээ латин монгол хольж бичих, олон улсын нэршлээр бичдэггүй монголоор бичсэн /дицинон-этамсилат, рибоксин-инозин/ гэх мэт, эмийн тун хоорондын зай, эмийн хэлбэр хэрэглэх аргыг тодорхой бичдэггүй зэрэг алдаа зөрчил илэрч, холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм худалдах зөвшөөрөлтэй 1 эм ханган нийлүүлэх байгууллага, мансууруулах эм худалдах тусгай зөвшөөрөл авсан 4 эмийн сан, сэтгэц нөлөөт эм худалдаалах зөвшөөрөл авсан 7 эмийн сан үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрт МХГ, Тагнуулын газар, ЭМГ-ын хамтарсан шалгалтаар мансууруулах сэтгэц нөлөөт эмийн хадгалалт, зарцуулалт, орлого, зарлагын бүртгэлд хяналт тавьж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд урьдчилан сэргийлэх хяналтаар мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийг зохих журмын дагуу тусгайлан битүүмжилж, зориулалтын шүүгээнд хадгалдаг, орлого зарлагын бүртгэлийг үнэн, зөв, бүрэн хөтөлж, шаардлага хангасан жороор үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхийг үндэслэн олгож хэвшсэн байна.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь нийт 464 өвчтөн хэвтэн эмчлүүлэх ортой бөгөөд эмийн сангийн стандартаар 50 ор тутамд 1 эм зүйч ажиллах ёстой бөгөөд одоогийн байдлаар БОЭТ-ийн 5 тасагт эм зүйч тасагт ажиллаж байна. Тухайлбал төрөх нярай, ЯТЭЭМТ - мэдрэл, хүүхэд - халдварт, дотор, гэмтэл-мэс заслын тасагт тус тус 1 эм зүйч ажиллаж байгаа ба хөнгөвчлөх-уламжлалт, сүрьеэ, сэтгэц, түргэн тусламж, амбулатори /Сүрьеэ,БЗДХ,ДОХ/-ийн тасгуудад эм зүйчийн орон тоо дутуу байна. Мөн нөөцийн тасаг нь 2 эм зүйч эсвэл 1 эм зүйч, 1 эм найруулагч гэсэн орон тоотой байх ёстой боловч 2 орон тоо дутагдалтай байна.



Жаргалант сумын ЭМТ нь 24 ортой бөгөөд эм зүйчийн орон тоо байдаггүй, эмийн санч - бага эмч ажилладаг байна.

Хувийн хэвшлийн 10 эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба орон тооны эм зүйчгүй, эмийн сангуудтай гэрээ байгуулж, эм зүйчийн ажлыг гүйцэтгүүлдэг байна.

Орхон аймагт 91 эм зүйч, 115 эм найруулагч ажиллаж байгаа бөгөөд стандартад заасан ажиллах хүний нөөцийн хангалт 95%-тай байна.

Зайлшгүй шаардлагатай эмийн 8-р жагсаалтад эмийн санд байвал зохих эмийн хангамж эм ханган нийлүүлэх байгууллагуудад дунджаар 88,4%-тай болж өмнөх оноос 3,4% хувиар нэмэгдсэн. Эмийн хангамж 1-р зэрэглэлийн эмийн санд 91,1%-тай, 2-р зэрэглэлийн эмийн санд 86,2%-тай байна. Энэ хугацаанд шинээр 70 эмийн сан Эрүүл мэндийн даатгалын тасагтай гэрээ байгуулан хөнгөлөлттэй үнээр иргэдэд үйлчилж байна.

БОЭТ-ийн хэмжээнд 2018 онд 139 нэр төрлийн эмнэлгийн хэрэгслийг 530.0 сая төгрөгөөр нийлүүлсэн нийт эмийн төсвийн 30%-ийг, 2019 онд хэрэглэсэн эм эмнэлгийн хэрэгслийн зарцуулалт эмийн төсвийн үлдэгдэл болон бүх тасаг нэгжүүд төсөвт үнээс хэтрүүлж зарцуулсан байна.

2019 онд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч болон хагалгааны тоо нэмэгдсэн, хэвлийн диализ эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнүүд зарим тохиолдолд гемодиализ эмчилгээнд төлөвлөгдөөгүйгээр ордог, бөөрний хурц дутагдал, хордлогын улмаас яаралтай гемодиализ эмчилгээнд орох зэргээс шалтгаалсан байна.

АШУҮИС-ийн харьяа Эм зүйн сургуулийн “Удирдлагын шинжлэх ухааны чиглэл”-ийн онлайн сургалтад Орхон аймгаас 2020 онд 12 эм зүйч, 2021 онд 10 эм зүйч элсэн суралцан төгсөж мэргэжил дээшлүүлсэн байна.

Ковид -19 цар тахалтай холбоотойгоор төгссөний дараа “эм барих” гэрчилгээг сунгахад шаардлагатай жилд цуглуулах 6 кредитийг 2020 онд ЭМЯ-аас суралцсанаар тооцон олгосон байна.

Орхон аймагт ЭМДЕГ-тай гэрээ бүхий 69 эмийн сан үйл ажиллагаа эрхэлж байгаагаас эм найруулагч ажиллуулж буй 21 эмийн сан байна.

Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эмийн сангуудын Эм холбооноос төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөр, сургалттай холбоотой санал хүргүүлээгүй байна.

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2017-2021 оны төлөвлөгөөний хүрээнд иргэдэд эмийн зохистой хэрэглээний чиглэлээр “Антибиотикийг жороор олгож хэвшицгээе” аяныг 3 удаа, “Жор бичилтийн аян”-ыг 2 удаа зохион байгуулсан байна. Эмийн сангууд “Антибиотикийн 7 хоног”-т зориулж 10-р сард “Нянгийн тэсвэржилтээс сэргийлье” аяныг зохион байгуулж, зурган мэдээлэл байршуулдаг байна.

Энгийн эмийн жор бичилтийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад энгийн эмийн жорын хангалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд нэг сарын аян зохион байгуулсан байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эм зүйч, эм найруулагч, иргэдэд чиглэсэн 16 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 744 хүнийг хамруулан зохион байгуулжээ.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй болон амбулаториор үйлчлүүлж буй 1,845 иргэнд антибиотик эмийн хэрэглээ, эмийн зохистой хэрэглээ чиглэлээр сургалт, мэдээлэл хийсэн байна. Мөн ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн төвийн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, зураглаач нартай хамтран эмийн зохистой хэрэглээний чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон социал орчинд мэдээлэл хүргэсэн байна.

ЭМГ, эмнэлэг, эм хангамжийн байгууллага, эмийн холбоотой хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэдэд эмийн зохистой хэрэглээний боловсролыг



дээшлүүлэх сургалт, сурталчилгааг тодорхой хэмжээнд жил бүр зохион байгуулсан ч нэгтгэн, үнэлж дүгнээгүй, үр дүнг тооцоогүй байна. Харин аймгийн хэмжээнд антибиотикийг жороор олгож байгаа байдал нэмэгдэж, жоргүй эм олгох асуудал буурсан талаар тайланд дурдсан байна.

Эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааг төлөвлөлт, зохион байгуулалт сайтайгаар орон нутгийн түвшинд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сувгуудыг ашиглан тогтвортой урт хугацаанд, тогтмол, зохион байгуулж, үр дүнг үнэлж ажиллах шаардлагатай байна. Тухайлбал нийгмийг хамарсан, иргэдэд бүрэн хүрсэн нөлөөллийн аянууд болох 1 хором, Хүн бай, Дураараа биш дүрмээрээ гэх зэрэгтэй дүйцэхүйц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Улсын хэмжээнд эмийн зохистой хэрэглээний талаарх асуумж, судалгааг нэгдсэн байдлаар зохион байгуулж үнэлгээг гаргах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрөөс эм, эмнэлгийн хэрэгслийг хууль, журмын дагуу бүртгэж байгаа ч эмийн хангалт, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлого тодорхойгүй байна.
- Эмийн санхүүжилт жил бүр нэмэгдэж байгаа боловч зарцуулалтад хяналт тавих иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, мэдээлэл дутмаг, зарим тохиолдолд хяналт хэрэгжихгүй эрсдэл үүсэхээр байна.
- Эмийн зохицуулалт, хяналтын үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтаар хангах тогтолцоо бүрдээгүй, эм зүйн салбарын хүний нөөцийн бодлого тодорхойгүй байна.
- Төрөөс эмийн талаар баримтлах бодлогын төлөвлөгөө боловсруулдаггүй, хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй бөгөөд эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын зорилтоор хэрэгжүүлсэн ч үр дүн тодорхойгүй байна.
- Эмийн зохистой хэрэглээний боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааг төлөвлөлт, зохион байгуулалт сайтайгаар орон нутгийн түвшинд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сувгуудыг ашиглан тогтвортой урт хугацаанд, тогтмол, зохион байгуулж, үр дүнг үнэлж ажиллах шаардлагатай байна.

Аудитаар нийт 6 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 2 саналыг хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 8.1-д “Эрүүл мэндийн тухай хуулийн 22.3-т заасан зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн эм барих үйл ажиллагаа эрхэлнэ.” гэсэн нь 2011 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн Эрүүл мэндийн тухай хуулиар хүчингүй болсон 1998 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн Эрүүл мэндийн тухай хуулийн заалтын хүрээнд бичигдсэн байна.



Эрүүл мэндийн тухай хуулийн 25.1-д “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн үзүүлэх бөгөөд зөвхөн зөвшөөрөл олгосон төрлөөр тусламж, үйлчилгээ үзүүлнэ.” гэж тодорхой тусгагдсан тул Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн дээрх заалтыг хасах талаар санал хүргүүлэх.

2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм худалдах тусгай зөвшөөрлийг эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгохоор, тусгай зөвшөөрөл авахаас бусад эм хангамжийн байгууллагатай холбогдсон харилцааг Эрүүл мэндийн тухай хуулиар зохицуулахаар тусгагдсан байна. Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 24.1-д “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтар бодисыг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна” гэж заажээ.

Дээрх хуулийн хүрээнд эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох эрх нь аймгийн Засаг даргад олгогдоогүй байна. Гэтэл Эрүүл мэндийн тухай хуулиар эм хангамжийн байгууллагад аймгийн Засаг дарга тусгай зөвшөөрөл олгохоор зохицуулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д:

- Аймгийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2018-2021 оны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, холбогдох журамд нийцүүлэн ажиллуулах, хариуцлагагүй ажилласан албан тушаалтанд хариуцлага тооцох.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст:

- Даатгалын сангийн зарцуулалтад хяналт тавихад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс e-daatgal аппликейшиныг суртчилан таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн ашиглаж буй health.go.mn программаас өмнөх оны мэдээллийг чөлөөтэй гаргаж болдог болгох.

Эрүүл мэндийн газарт:

- Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдэд олгосон амин дэмийг ууснаар хэрхэн амин дэмийн дутагдал арилсан талаар тооцоо судалгаа хийж, үр дүнг тооцож байх.
- Байгууллагын хүний нөөцийн байдалд дүн шинжилгээ хийж, тогтвор суурьшилтай үр дүнтэй ажиллахад анхаарч, ажлын хариуцлагыг дээшлүүлэх.
- Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, сургалт, сурталчилгааны ажлуудыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сувгуудыг ашиглан олон нийтэд хүртээмжтэй зохион байгуулж, үр дүнг үнэлэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.